

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧИН
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНИЙ 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг: Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт.

№	Зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн тайлан				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт. 1							
1.	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор байгаль орчны эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчил өмнөх оноос буурч, иргэдийн хандлага өөрчлөгдсөн байх;	Гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Байгаль орчны багц хууль түүнийг дагалдан гарсан дүрэм журмыг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг цахим орчинд постер, боршур, шторик, видео контент байршуулах хэлбэрээр зохион байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, байгаль орчны эсрэг гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлсэн	Байгаль орчин аялал жуулчлалын газраас ирүүлсэн удирдамж, чиглэлүүд, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах зорилтоор Цагдаагийн албан хаагчидтай хяналт шалгалт зохион байгуулж ажиллаж байна. Байгаль орчны хууль тогтоомж журмыг олон нийтэд мэдээлэх талаар цахим орчинд шторк, контент байршуулах, иргэдэд гарын авлага тараах зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Нарийнтээл сумын Баянтээг 2 дугаар багт "Тахь Ресорс" ХХК 2024 оны 11 дүгээр сард Нүүрсний давхаргын метан хийн ОНГИ 5 талбайд метан хийн хайгуулын талбайд долгион хэмжих ажил хийгдсэн. Мөн "Хаан хийлс" ХХК 08 дугаар сард хайгуулын талбайд хайгуулын ажил хийгдсэн. Хяналт тавьж ажилласан.	2024.01.01-2024.12.31	100

				байна.			
2.	Байгаль орчныг хамгаалах багц хуулиудын хэрэгжилтэнд хяналт тавих, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх, зөрчлийг арилгах, хариуцлага тооцох;	Байгаль орчныг хамгаалах багц хуулиудын хэрэгжилтэнд хяналт тавьсан шалгалтын тоо шийдвэрлэсэн байдал;	Иргэдийн Байгаль орчны мэдэлгийг сайжруулах, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах эрх зүйн мэдлэгтэй болгох	-Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэдийн гомдол, мэдээллийн дагуу хууль хяналтын байгууллагуудт ай хамтран гүйцэтгэж хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байх -Хяналт шалгалттай холбоотой мэдээ тайланг хагас бүтэн жилээр гаргаж БОАЖГазарт хүргүүлсэн байна	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд эргүүл хяналт шалгалтын ажлыг удирдамж чиглэлийн дагуу хяналт шалгалтыг сумын цагдаагийн албан хаагчидтай хамтран ажиллаж байна. хууль бусаар ашигт малтмал олборлосон 3 иргэн, хууль бус ан хийж тээвэрлэсэн 9 иргэн, хууль бусаар ашигт малтмал олборлосон 3 иргэн холбогдох газарт шилжүүлэн зөрчлийн хэрэг нээж хуулийн дагуу арга хэмжээ авхуулсан. 8 иргэнийг хууль журмын дагуу хялбаршуулсан журмаар торгуулийн арга хэмжээ авч, нөхөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авч, 1 иргэнийг зөрчлийн хэргийн материалыг прокурорт хүргүүлж хүлээн авахаас татгалзаж хэрэгсэхгүй болгосон./нөхөн төлбөр болох 13.300.000 мян.төг төлүүлсэн./ Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд эргүүл хяналт шалгалтын ажлыг удирдамж чиглэлийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэн ажиллаж байна. Нарийнтээл сумын 2 дугаар багийн	2024.01.01-2024.12.31	100

					нутагт үйл ажиллагаа явуулж байгаа "Импери майнинг" ХХК-ийн үйл ажиллагааг иргэнээс гаргасан өргөдөл гомдлыг Цагдаагийн газарт шилжүүлэн шийдвэрлэсэн. Тандалт судалгаа, хяналт тавих замаар эргүүл хяналтын ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна.		
3.	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, хүүхэд залуучууд ЕБС-ийн сурагчдад экологийн боловсрол, ногоон хөгжлийн талаарх мэдээллийг сумын пэйж хуудсаар дамжуулан хүргэх;	Тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд экологийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлууд зохион байгуулсан байдал	ЕБСургуулийн сурагчдад экологийн боловсрол олгох, мэдлэг чадварыг нь дээшлүүлэх	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлж, хүүхэд залуучууд ЕБС-ийн сурагчдад экологийн боловсролыг сайжруулна.	"Mini Youth In Nariintee" Байгальд ээлтэй сурагчдын чуулганыг амжилтай зохион байгуулж тус арга хэмжээнд нийт 54 сурагч оролцож байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоог сайжруулах, хүрээлэн буй орчноо сайжруулах, байгалиа хамгаалах талаар сургалт сурталчилгаа хийж бусдадаа танилцуулах зэргээр мэдээлэл хийж тус сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчидтай хамтран зохион байгуулсан.	2024.01.01-2024.12.31	100
4.	Байгалийн баялгийг зохих шийдвэрийн дагуу зүй зохистой ашиглуулж төлбөр хураамжийг бүрэн барагдуулах	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого төвлөрүүлэлт, зарцуулалт, тайлагналт;	Хяналт шалгалтийг тогтмол хийж хэрэгжүүлэх	Байгалийн дагалт баялаг ашиглахад хяналт тавьж, эрхийн бичиг олгож, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж,	Ашигт малтмал эрж хайх хайгуулын 5 компани Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөгөө батлуулж байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төвлөрүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр төсөвт төвлөрөх орлогыг бүрдүүлж хяналтыг тавьж журмын дагуу тавьж ажилласан.	2024.01.01-2024.12.31	100

				дүн мэдээг хуульд заасан хугацаанд холбогдох газруудад тайлагнасан байна.			
1.2 “БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ, ДОРОЙТСОН ГАЗРЫГ НӨХӨН СЭРГЭЭХ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
5.	Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, биотехникийн арга хэмжээ авах;	Биотехникийн арга хэмжээ авсан тоо	Гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Агнуурын бүс нутаг болох Өшгөгийн нуруунд Биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах	“Тахилгат мандаа Өшгөг” байгаль хамгаалах нөхөрлөлтэй хамтран жил бүр хужир мараа тавих хөв цөөрмийг сэргээх ажлыг хавар намрын улиралд хийж гүйцэтгэж байна.	2024.01 .01- 2024.12 .31	70
6.	Сум тус бүр булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалан, орон нутгийн өмчид бүртгэх;	Нэн шаардлагатай булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалах	Усны хомсдолоос урьдчилан сэргийлэх	Уст цэгийн тооллогыг мэргэжлийн байгуулагуудтай хамтран хийж гүйцэтгэж, 1-2 булгийн эхийг хашиж хамгаалах арга замыг судлах.	2024 онд Баянтээг 2 дугаар багт Хашаалах шаардлагатай булгийн судалгааг хүргүүлж аймгийн Байгаль орчны газраас булгын эхийн хашаажуулах 95 ширхэг шургаар Баянтээг 2 дугаар багт Дэрсэн булаг, эхэн Зүлэгтийн булга, цагаан-Овоо 4 дүгээр багт Уртын амны булгыг хашаалахад. Булгийн эхийг 4 метр шургааг, 1,5 метр арматур ашиглан чартаалан өрөх зүү сүвлэх аргаар 5-н тал болон 6-7 тал хана босгож хашаалахаар болсон.	2024.01 .01- 2024.12 .31	100
7	Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин байршил, цэг тэмдэгтийг тодотгох	Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан бичил уурхайн нөхөрлөлүүдийн тоогоор	Хяналт шалгалт тогтмол хэргэжүүлэх	Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан бичил уурхайн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа явуулах талбайн цэг	2024 онд бичил уурхайн зориулалтаар дүгнэлт талбайн хугацаа дууссан учир бичил уурхайн үйл ажиллагаа явагдаагүй болно. “Империо майнинг” ХХК ашиглагласан талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 24 га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгдэж аймгийн Байгаль орчин, Онги-Таац голын сав газрын захиргаанаас ажлын ажлын хэсэг ирж, Здтг-с хамтарсан ажлын хэсэг гарч тухайн	2024.01 .01- 2024.12 .31	100

				тэмдэгтийг тодорхойлж байнгын хяналт тавьж ажиллах	нөхөн сэргээлтийн ажилтай танилцаж тухайн газрыг хүлээн авсан. Ашигт малтмал эрж хайх хайгуулын 2 компани болох "Хан хийлс"ХХК, "Тахь ресорс" ХХК 2024 оны 08 дугаар сарын 01-с 11 дүгээр сарын 30 хооронд хайгуулын талбайд хайгуулын ажлыг хийж гүйцэтгэж тухайн талбайг нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн.		
8	Алтны хайгуулын болон ашиглалтын компаниудын үйл ажиллагаа явуулсан тухай бүр нь нөхөн сэргээлт хийлгэх	Алтны хайгуулын үйл ажиллагаа явуулсан компаний тоогоор	Хяналт шалгалт тогтмол хэргэжүүлэх	Хайгуулын ажилд хяналт тавьж ажилласан байна. Нөхөн сэргээлт хийлгэж хяналт тавьж ажилласан байна.	2012.07.04 өдрийн 222 тоот сайдын тушаалын хүрээнд 2021 онд Ашигт малтмалын тухай хуулийн 7.3, 38.1.8 зүйл заалтаар тусгай хайгуулын зөвшөөрөлтэй "Империо майнинг" ХХК, "Цагаан уулын магнит" ХХК, "Ургах шигтгээ" ХХК, "Хаан хийлс"ХХК, "Тахь ресорс" ХХК зэрэг 5 ААН байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөгөө батлуулсан. 2 хайгуулын кампани Хайгуулын ажил хийсэн.	2024.01.01-2024.12.31	100
9	Ховор, нэн ховор болон бусад амьтан ургамлын нөөцийн судалгааг хийх, хамгаалалтыг сайжруулах	Ургамал, амьтны аймгийн мэдээллийн сан үүсгэх	Мэдээлэлийн сан үүсгэх	Ховор, нэн ховор амьтан ургамлын мэдээллийн сантай болсон байна	Тус сумын Өндөр хөмөр 3-р баг, Цагаан-Овоо 4-р багын нутгууд болон Баянтээг 2-р багийн нутаг Өшөөгийн нуруунд аргаль хонь тархан амьдардаг. Энэ жилийн хувьд нэн ховор зарим нэг амьтад сумын зарим хэсэгт үзэгдэх, тархан байршсан байна. Халиун буга 1,3,4-р багт, Цоохор ирвэс 2-р багийн нутаг Шаргын хад гэх газар суурьшаад байна.	2024.01.01-2024.12.31	100
10	Сумын төвийн ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоож, хашаажуулах	Хуучин тогтоосон бүсийг шинэчилж, хашаажуулсан эсэх	Эрүүл ахуйн бүс тогтоох	Ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоож, хашаажуулах ажлыг судлах.	Нарийнтээл сумын СӨББ, Эрүүл мэндийн төвүүдийн худгаас эрүүл ахуйн шинжилгээ хийлгэх дээж авч Өвөрхангай аймгийн төв лабораторид хүргүүлж шинжилгээний хариу сайн гарсан. Баянтээг 2 дугаар багийн ундны усны худагт "Мөнх ану"	2024.01.01-2024.12.31	100

					ХХК нь /5.997.0мян.төг/-өөр худагт цэвэршүүлэгч тавих ажил хийгдсэн. Худагт 1 ширхэг РР хөвөн шүүлтүүр SS-304 Зэвэрдэггүй ган гэртэй, 1 ширхэг UF-8000L/H membrane шүүлтүүр тавьж суурилуулсан.		
1.3 “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН, НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД							
Зохион байгуулалтын чиглэлээр							
1.	Мод бут тарих, хог хаягдлыг бууруулах чиглэлээр иргэд олон нийтэд хандсан сургалт, сурталчилгаа хийх	-Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Иргэдийг мэдээлээр хангах	Мод бут тарих, хог хаягдлыг бууруулах чиглэлээр иргэд олон нийтэд хандсан сургалт 2-оос доошгүй удаа зохион байгуулагдаж, үр дүнд хүрсэн байна	Бүх нийтээр мод тарих" хаврын өдрүүдэд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн."Тэрбум" мод үндэсний хөдөлгөөн 2024 оны 05 сарын 10-с 05 дугаар сарын 30 өдөр хүртэл мод тарих ажил явагдаж дууссан. Нийт 3 албан байгууллага 28 иргэн мод тарьсан байна. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдийн хүрээнд нийт 3 төрлийн 2376 ширхэг мод, бут тарьсан. Нийт тарьсан модны 63 ширхэг модыг айл өрх, 2313 ширхэг модыг ЗДТГ-с төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид тарьж ургуулж байна. "Империо майнинг" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд 200 ширхэг мод өгч тарих ажил хийгдсэн. Намрын мод тарилтын өдрүүдээр 1000 ширхэг бургас " Бат цэцэрлэгжилт" ХХК-с худалдан авч тарих ажлыг хийж гүйцэтгэсэн. Сумын нийтийн эзэмшлийн талбайд нийт 3376 ширхэг мод тарьж ургуулсан. Хөдөлмөр халамжийн газраас Хавар 5 иргэнийг, намар 5 ажлын байраар хангаж нийт 10 иргэн мод тарих ажилд хамруулан түр ажлын байраар хангаж ажилуулсан. Иргэд идвэх санаачлаг сайтай ажилласан.	2024.01.01-2024.12.31	100

2.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд мод тарих арга хэмжээг зохион байгуулах;	Тарьсан модны тоо, ургалтын хувь	Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Аж ахуйн нэгж иргэдийг идвэхтэй хамруулсан байна.	Бүх нийтээр мод тарих" хаврын өдрүүдэд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн."Тэрбум" мод үндэсний хөдөлгөөн 2024 оны 05 сарын 10-с 05 дугаар сарын 30 өдөр хүртэл мод тарих ажил явагдаж дууссан. Нийт 4 албан байгууллага 32 иргэн мод тарьсан байна. Хаврын улиралд 2376, намрын улиралд 1000 ширхэг мод тарьсан.	2024.01 .01-2024.12 .31	100
3.	Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудтай ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг бууруулах талаар гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах	Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж орчны бохирдолыг бууруулах, хог хаягдлын хэмжээг багасгаж ангилан ялгалт хийлгэж хэвшүүлэх	Иргэд аж ахуйн нэгж, албан байгууллагийг идвэхтэй хамруулах	Тарисан модны ургалтыг сайжруулах усалгаа арчилгааг сайжруулах, хог хаягдлын хэмжээг багасгаж бууруулсан байна	Албан байгууллага, аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудад Хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг байрлуулах, цаашид ангилан ялгаж сурах талаар албан шаардлага хүргүүлж мэдээллээр хангаж ажиллаж байна.	2024.01 .01-2024.12 .31	100%
4	Мод тарих зөвлөмж, гарын авлагыг бэлтгэж иргэдэд түгээх, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Иргэдэд үзүүлсэн арга хэмжээний тоогоор	Сургалт сурталчилгаа хийх мэдээлээр хангах	Тарих модны талаарх танилцуулгыг мод тус бүрээр бэлтгэн, мод хэрхэн тарих талаарх зөвлөмжийг бэлтгэн, Нарийнтээл сум, Баянтээг багийн пэйж хуудсаар дамжуулан иргэдийг мэдээллээр хангаж ажилласан байх. Сумын хэмжээнд 2024	Хавар намрын мод тарих өдрүүдэд байгууллага аж ахуйн нэгж иргэдийг уриалж оролцуулж байна. 3 албан байгууллага, 28 иргэн мод тарих ажилд идэвхтэй оролцсон. Мөн Хөдөлмөр халамжийн газраас 10 иргэнийг ажлын байраар хангаж мод тарих ажилд хамруулан түр ажлын байраар хангаж ажилуулсан. Иргэд идвэх санаачлаг сайтай ажилласан.	2024.01 .01-2024.12 .31	100%

				онд 20000 ширхэг мод тарьсан байх			
5	Тэрбум мод үндэсний хөдөлгөөны хүрээнд мод тарих арга хэмжээг зохион байгуулан ногоон байгууламж шинээр байгуулах, өргөтгөх ажлыг хэрэгжүүлэх	Шинээр нэмэгдсэн байгууламжийн хэмжээ Тарисан модны ургалтын хувь	Иргэдэд үзүүлсэн арга хэмжээний тоогоор	Тарих модны талаарх танилцуулгыг мод тус бүрээр бэлтгэн, мод хэрхэн тарих талаарх зөвлөмжийг бэлтгэн, Нарийнтээл сум, Баянтээг багийн пэйж хуудсаар дамжуулан иргэдийг мэдээллээр хангаж ажилласан байх. Сумын хэмжээнд 2023 онд 10000 ширхэг мод тарьсан байх	2024 онд сумын хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэн хуучин суулгасан тарьц суулгацын ургалтыг нэмэгдүүлэх, арчилж тордон чанарыг сайжруулах асуудлыг гол чиглэл болгон ажиллаж байна. Иймд ургалтын чанарыг нэмэгдүүлэх хуучин тариалсан мод суулгацаа арчилж тордох ажлыг хийж модны усалгаа арчилгаа хийх нэг хүнийг ажлын байраар хангаж сумын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэж байна. хүрээлэн байгуулахаар төлөвлөж мод бут тарих ажил хийгдсэн.	2024.01 .01- 2024.12 .31	100%
6	"Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022-2030 хүртэл хугацаанд мод тарих боломжтой газруудын байршил, судалгааг гаргаж, ажлын төлөвлөгөө боловсруулах	Мод тарих талбайг сонгох, байршил талбайн хэмжээг гаргах боломжтой газруудад судлах, судалгааг гаргах	Сонгосон газруудыг хашаажуулах, мод тарих ажлыг эхлүүлэх, усалгаа арчилгааг сайтар хийж ургуулах	2024 онд сумын хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэн хуучин суулгасан тарьц суулгацын ургалтыг нэмэгдүүлэх, арчилж тордон чанарыг сайжруулах асуудлыг гол чиглэл болгон ажиллаж байна. Иймд ургалтын чанарыг нэмэгдүүлэх хуучин тариалсан мод суулгацаа арчилж тордох ажлыг хийж модны усалгаа арчилгаа хийх нэг хүнийг ажлын байраар хангаж сумын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Сумын баруун гуанзны төв зам дагуу нийт 14 га талбайг хашаажуулан цэцэрлэг хүрээлэн байгуулахаар төлөвлөж мод бут тарих ажил хийгдсэн. 2021-	2024.01 .01- 2024.12 .31	100%	

				2024 онд тус талбайнуудад 21489 ширхэг мод бут мод тарилтын ажил хийгдэж байна. Ургалтын 80 хувьтай ургаж байна.			
Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр							
7	Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийг камержуулах. Талбайн хэмжээг багасгах	Эмх замбараагүй асгах байдлыг бууруулах	Хяналт тогтмол тавих	Ангилан ялгалт хийлгэх, хоёрдогч түхий эд авах цэг байгуулах, хогын цэгийн хашааг засварлуулах, хогны хэмжээг багасгуулах	Сумын төвийн хогийн цэгийг түрж тэгшлэх ажлыг сар бүр хийж гүйцэтгэж байна. Шарга 1 дүгээр багт үүссэн хогийн цэгийг дарж тэгшлэх ажил хийгдсэн. Баянтээг 2 дугаар багийн хогийн цэгийг хашаажуулах ажлыг "Империо майнинг" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд хашаажуулж өгсөн. Сумын төвийн хогийн цэгийг камержуулах ажил орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэнэ. Одоогоор тендер нь зарлагдаагүй байгаа.	2024.01.01-2024.12.31	70%
8	Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн цэгт аюултай хог хаягдлыг устгах, шатаах цэг байгуулан ашиглах горим тогтоон мөрдүүлэх, аюултай хог хаягдлын толлогыг зохион байгуулж, химийн бодисыг мэргэжлийн байгууллагаар устгуулах арга хэмжээ авах	-аюултай хог хаягдал, бодисы судалгаа гаргах, -аюултай бодисын тооллого зохион байгуулах, бүртгэлийн сантай болох	Мэдээлэлийн сан бүрдүүлэх	Аюултай бодисийн судалгааг гаргах устуулах шардлагтай бодисыг мэргэжлийн байгуулгаар устгуулж мэдээлийн сантай болсон байна.	Аймгийн хэмжээний устгах шаардлагатай химийн бодис устгах ажилд оролцож Ерөнхий боловсролын сургуулийн химийн кабинетад хадгалагдаж химийн бодисуудын судалгааг гаргаж аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлсэн.	2024.01.01-2024.12.31	100%

9	Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд, нийтийн эзэмшлийн гудамж талбайд хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байршуулах ажилд оролцох;	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савны тоог нэмэгдүүлсэн байдал	Иргэдийг мэдээлэлээр хангах, ангилж ялгаж хэвшүүлэх	Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хог хаягдал ангилан ялгах талаарх мэдээллээр хангаж, хог хаягдлыг ангилан ялгах савыг байршуулан, ангилан ялгах ажлыг эхлүүлсэн байна.	Албан байгууллага, аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудад Хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг байрлуулах, цаашид ангилан ялгаж сурах талаар албан албан мэдэгдэл зөвлөмж тарааж Албан байгууллага, аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудад Хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг байрлуулах, цаашид ангилан ялгаж сурах талаар албан шаардлага хүргүүлж мэдээллээр хангаж ажиллаж байна. Сумын төвийн хаягдлын менжемэнтнийг сайжруулах бодлогыг баримталж нэг иргэнийг дахивар бүтээгдэхүүн авах цэг байгуулахад дэмжиж ажиллаж байна.	2024.01.01-2024.12.31	70%
	1.4.1. - Баянтээг 2 дугаар багт, Цагаан-Овоо 4 дүгээр багуудад 2024 оноос хуванцар сав, шил, лааз, болон дахивар бүтээгдэхүүн авах цэг байгуулгаж ашиглалтад оруулах	Хог хаягдлыг ангилан ялгаж дахивар бүтээгдэхүүн авах цэгт тушаалган хэвшүүлсэх ажлыг зохин байгуулах	Дахивар бүтээгдэхүүн авах цэг байгуулах	Хог перэслэгч төхөөрөмж 2 ширхгийг нийгмийн хариуцлагын гэрээнд тусгагдсаны дагуу авч өгсөн.	Нарийнтээл сумын Цагаан-овоо 4 дүгээр багт ирэн н.Бямбадорж нь хог преслэгчийг ашиглан дахивар бүтээгдэхүүн цуглуулах шил, лааз, хуванцар сав, төмөр болон бусад ашиглагдаж болох дахивар бүтээгдэхүүнийг ангилан авч байна. Баянтээг 2 дугаар багт 1 ширхэг хог преслэгч хүлээлгэн өгсөн одоогоор ашиглаагүй байгаа.	2024.01.01-2024.12.31	70
10	Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах;	Нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж хэвшсэн байх	Улирал бүр цэвэрлэгээ хийлгэх	Нийтийн их цэвэрлэгээг ААН, байгууллага, иргэдийг хамруулан жилд 4-5 удаа зохион байгуулна.	Бүх нийтийг хамарсан их цэвэрлэгээ хийх ажилд иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд идэвхтэй оролцож сумын хэмжээнд нийт 30 гаруй тонн хог хаягдал цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт асгах ажил хийгдсэн. Мөн "Баянтээг" ХК машин, ковшоор тусалж хамтаран ажиллаж Баянтээг 2 дугаар багийн гудамж хороолол болон орны хог хаягдлыг цэвэрлэх ажилд тус багийн иргэд идэвхтэй оролцсон. Хавар намрын улиралд Таацын гол дагуух	2024.01.01-2024.12.31	100%

					дэрс болон гуанзны ойр орчмын хуримтлагдсан хогийг цэвэрлэх ажлыг аж ахуй нэгж, албан байгууллагаар хийлгэж, улиралд нэг удаа иргэдээр гудамж, нийтийн эзэмшлийн талбайд 50-100 метрт орчны хог хаягдлын цэвэрлүүлж бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан. Айл өрхийн хог хаягдлыг сард нэг удаа хог тээврийн машинд нэгдсэн журмаар ачиж байна.		
11	Хөдөөгийн айл өрхүүд өвөлжөө, хаваржаа, зусландаа жишиг загварын ариун цэврийн байгууламжтай болох, булаг шанд, голын эх, малын бэлчээр, уул овоо, төв суурин газрын хаалга орчмын хог хаягдлыг сумын төвийн төвлөрсөн хогийн цэгт хүргүүлэх, устгуулах ажлыг зохион байгуулах.	Нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж хэвшсэн байх	Улирал бүр хийж хэвшүүлэх	Нийтийн их цэвэрлэгээг ААН, байгууллага, иргэдийг хамруулан жилд 4-5 удаа зохион байгуулна.	ЗДТГ-йн албан хаагчид малчидтай хамтран сэг зэм цэвэрлэх ажлыг 4 сард зохион байгуулж 4 багийн хэмжээнд гол горхи, зам, дагуу болон бусад газруудад их хэмжээгээр хуримтлагдсан малын сэг зэм цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэж тогтоосон цэгүүдэд цуглуулж ариутгал хийж дарж, булах ажлыг гүйцэтгэж ажилласан. Нийт 2000 гаруй үхсэн малын сэг зэм утгах ажил хийгдсэн. Цагаан-овоо баг болон Баянтээг багуудад нохой устгах ажлыг зохион байгуулж нийт 120 ширхэг нохойг устгаж булж арах ажлыг хийж гүйцэтгэсэн.	2024.01.01-2024.12.31	100%
12	Сумын төв, Баянтээг багийн төвийн гэр хороололд "Эко жорлон" арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгжүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.	"Эко жорлон" болон жорлонгоо өөрчилсөн айл өрхүүдийн тоогоор	Хөрсны бохирдолыг бууруулах	Сум, багийн нутаг дэвсгэрт "Эко жорлон" арга хэмжээг зохион байгуулах	2024 онд Орон нутгийн сангийн хөрөнгөөр Сумын баруун гуанзны урд төв зам дагуу 2 ширхэг "Эко" 00 суурилуулах ажил хийгдэж ашиглалтад оруулсан.	2024.01.01-2024.12.31	70%
1.4.Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодолгыг хэрэгжүүлэх, аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулж ажиллана.							
1	Байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын маршрутыг бий болгох, түүнд түшиглэсэн соёлын үйлдвэрлэл болон брэнд бүтээгдэхүүн бий болгох	Орон нутгийн аялал жуулчлалын маршруттай болсон байдал Шинээр бий болсон брэнд бүтээгдэхүүн	-	Аялал жуулчлалын маршрутыг баталж, түүнд түшиглэсэн соёлын үйлдвэрлэл	"Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд" "Цахим шилжилтий байна.г эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд" дижитал Өвөрхангай төслийн хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтоор аймаг сумдын нутагт байгаа Байгалын өвөрмөц тогтоц, түүх	2024.01.01-2024.12.31	100%

				болон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох	соёлын дурсгалт газруудын маршрутын мэдээллийг тухайн сайт, аппликэйшнд байршуулах зэрэг ажил хийгдэж байна.		
2	Орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд орчны бохирдол, хог хаягдлын нэгдсэн менежментийг хэрэгжүүлэн ажиллах	Стандартын шаардалгад нийцсэн хог хаях цэг, ариун цэврийн байгууламжийг бий болгосон байдал	-	Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх	2024 онд Орон нутгийн сангийн хөрөнгөөр Сумын баруун гуанзны урд төв зам дагуу 2 ширхэг "Эко" 00 суурилуулах ажил хийгдэж ашиглалтад оруулсан.	2024.01 .01- 2024.12 .31	100%
1.5. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Төрийн албаны тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	-Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрх, үүрэг, үйл ажиллагаанд хориглох зүйлийг хэрэгжүүлж ажилласан байх (Төрийн албаны тухай хуулийн 37,38,39 дүгээр зүйл)	-	-Архив албан хэрэг хөтлөлтийн талаар гарсан шинэ хууль, журам, стандартыг судлах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх -Авлига ашиг, сонирхлын зөрчил гаргаагүй байх;	Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдолтой хууль журмын дагуу ажил үүргээ гүйцэтгэж авлигал хээл хахууль ашиг сонирхлын зүйлээс ангид байж төрийн албыг ёс журамтай зөрчил гаргалгүй хийж гүйцэтгэсэн.	2024.01 .01- 2024.12 .31	100%
2	Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримталж ажиллах;	-	-	Ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчил гаргасан эсэх;	өрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримталж, ашиг сонирхлын зөрчил гаргалгүй олон нийт иргэдтэй зөв боловсон харицаж ёс зүйн алдаа гаргалгүй ажилласан.	2024.01 .01- 2024.12 .31	100%
3	Эрхэлсэн ажилтай холбоотой тайлан мэдээ судалгаан тогтоосон хугацаанд гаргаж тайлагнах;	-	-	Хугацаандаа тайлагнасан эсэх	Мэдээ тайланг тогтоосон цаг хугацаанд нь холбогдох газарт нь хүргүүлж ажилласан.	2024.01 .01- 2024.12 .31	100%

	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5 Албан тушаалтанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх;			Иргэдээс ирсэн гомдол мэдээлэл хугацаатай болон хариутай албан бичгийг тухай бүрд нь шийдвэрлэсэн	2024 он гарсаар хууль бусаар Ашигт малтмал олборлосон дуудлага 2, ашиглалт явуулж буй "Империо майнинг" ХХК холбоотой гомдол 1иргэнээс, бичил уул уурхайн 296 дугаар журмын дагуу 2023 онд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулсан нөхөрлөхийн нөхөн сэргээлтийн ажил дутуу хийгдсэн талаар иргэдээс гомдол мэдээлэл ирсэн. Хуульд заасан хугацаанд шийдвэрлэж холбогдох газарт хүргүүлж шийдвэрлэсэн.	2024.01.01-2024.12.31	100%


Нэмэлт үүрэг даалгавар /арга хэмжээ/-ийн биелэлт.

Нөмөр, үүрэг даалгавар, арга хэмжээг илтгэх биелэлт.							
№	Үүрэг даалгавар /арга хэмжээ/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Аймгийн Засаг даргын 2023оны 1 дүгээр сарын 29-ны 1/73 албан бичиг "Агаарын бохирдлын эхүүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах тухай	Агарын бохирдлын хэмжээг бууруулах	"Агаарын бохирдлын эхүүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах	Судалгааг гаргах мэдээлийн санд оруулах	. Эх үүсвэрийн тоо бүртгэлийг ажлын хэсэг гаргуулж сумын төв болон Баянтээг багт явуулж нийт 468 өрхийн мэдээллийг тогтоосон хугацааны дагуу "Орчны бохирдлын эх үүсвэрийн хаягдал тооллогын сан"-д байрлуулан шивж оруулсан. Мэдээ тайланг цаг тухайд нь гүйцэтгэж явуулсан	2024.01.06-2024.02.15	100%
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1.Төрийн албаны тухай хуулийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны	Мэдлэгээ дээшлүүлсэн байна.	-	Цахим болон танхимын сургалтанд	Төрийн албаны сургалтын байгууллагаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад	2024.01.01-2024.12.31	50%

	сургалтад хамрагдах			хамрагдсан байх	хамрагдаж байна.		
2.	Арга хэмжээ 2. Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	Холбогдох чиглэлээр сургалтанд хаарагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	-	Цахим болон танхимын сургалтанд хамрагдсан байх	Байгаль орчны чиглэлээр эрхэлсэн албан тушаалтай холбоотой сургалтад хамрагдаж байна.	2024.01.01-2024.12.31	50%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
/албан тушаал/

 /Г.НАРАНБААТАР/
/нэр, гарын үсэг/

2024.12.05
/огноо/